

2023 ОНЫ 07 ДУГААР САРЫН 03-НЫ ӨДӨР, ДАВАА ГАРАГ



# МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН 2023 ОНЫ ХАВРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАН

2023 ОНЫ 07 ДУГААР САРЫН 03-НЫ ӨДӨР, ДАВАА ГАРАГ

## ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ

БАЙНГЫН ХОРООНЫ  
ХУРАЛДААН



### ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ ХЭЛТЭС

Та хуралдааны тэмдэглэлийн цахим хувьтай дараах  
QR кодыг уншуулан танилцах боломжтой.

2023 ОНЫ 07 ДУГААР САРЫН 03-НЫ ӨДӨР, ДАВАА ГАРАГ

**БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА**  
**2023 оны 07 дугаар сарын 03-ны өдөр, Даваа гараг**

<i>Хуралдааны тэмдэглэлийн агуулга</i>	1
<i>Хуралдааны товч тэмдэглэл:</i>	1-11
<i>Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:</i>	12-22
<hr/>	
1. Улс төрийн намын тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүд /Монгол Улсын Ерөнхийлөгч 2023.04.14-ний өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/	12-18
2. Жендерийн эрх тэгш байдлыг хангах тухай хуульд өөрчлөлт оруулах тухай болон Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Улс төрийн намын тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/	18-19
3. Хуулийн давхардал, хийдэл, зөрчлийг арилгах зорилгоор боловсруулсан Үндэсний их баяр наадмын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай болон Хөдөлмөрийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүд /Засгийн газар 2023.06.23-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/	20-22

2023 ОНЫ 07 ДУГААР САРЫН 03-НЫ ӨДӨР, ДАВАА ГАРАГ

**Монгол Улсын Их Хурлын 2023 оны хаврын ээлжит чуулганы  
Төрийн байгуулалтын байнгын хорооны 07 дугаар сарын 03-ны өдөр  
/Даваа гараг/-ийн хуралдааны товч тэмдэглэл**

Төрийн байгуулалтын байнгын хорооны дарга Н.Энхболд ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 19 гишүүнээс 10 гишүүн хүрэлцэн ирж, 52.6 хувийн ирцтэйгээр хуралдаан 10 цаг 30 минутад Төрийн ордны “Үндсэн хууль” танхимд эхлэв.

Томилолттой: С.Бямбацогт, Г.Ганболд, Ц.Мөнх-Оргил, Х.Нямбаатар, Д.Сарангэрэл;

Чөлөөтэй: Ё.Баатарбилэг, Л.Оюун-Эрдэнэ;

Эмнэлгийн чөлөөтэй: Ц.Мөнхцэцэг;

Тасалсан: Ж.Эрдэнэбат.

**Нэг. Улс төрийн намын тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн төсөл бол хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүд /Монгол Улсын Ерөнхийлөгч 2023.04.14-ний өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/**

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Монгол Улсын Ерөнхийлөгчийн Хууль зүйн бодлогын зөвлөх А.Бямбажаргал, Үндэсний аудитын газрын Хөгжлийн бодлого төлөвлөлтийн газрын захирал, тэргүүлэх аудитор Б.Бундхорол, Сонгуулийн ерөнхий хорооны Ажлын албаны дарга Д.Баяндүүрэн, мөн хорооны Хууль, эрх зүйн хэлтсийн дарга Д.Бат-Эрдэнэ, Монгол Улсын Их сургуулийн Үндсэн хуулийн эрх зүйн хүрээлэнгийн захирал, Хууль зүйн сургуулийн профессор, хууль зүйн доктор О.Мөнхсайхан, мөн сургуулийн Улс төр судлалын тэнхимийн профессор Д.Бумдарь, судлаач Э.Гэрэлт-Од, Д.Энхцэцэг нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Б.Төгсцэнгэл, Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн дарга Д.Энхбат, мөн хэлтсийн референт Б.Галсанбат, Төрийн байгуулалтын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Б.Хатантуул, референт Э.Баттогтох нар байлцав.

Төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаар ажлын хэсгийн танилцуулгыг Улсын Их Хурлын гишүүн Д.Тогтохсүрэн танилцуулав.

Улс төрийн намын тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн төслийн талаар ажлын хэсгээс гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулав.

**Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн  
42 дугаар зүйлийн 42.2.1 дэх заалтын дагуу хураалгах санал:**

**Н.Энхболд:** 1.Төслийн 19 дүгээр зүйлд доор дурдсан агуулгатай 19.4, 19.5, 19.6 дахь хэсэг нэмэх:

“19.4.Нам Улсын Их Хурлын сонгуульд намаас нэр дэвшигчийг сонгох ажлыг зохион байгуулах хороотой байж болно. Хорооны бүрэлдэхүүнд тавигдах шаардлага, түүнийг байгуулах, ашиг сонирхлын зөрчлийг зохицуулах болон үйл ажиллагааны журмыг энэ хуулийн 8 дугаар зүйл, намын дүрэмд нийцүүлнэ.

2023 ОНЫ 07 ДУГААР САРЫН 03-НЫ ӨДӨР, ДАВАА ГАРАГ

19.5. Улсын Их Хурлын сонгуульд намаас нэр дэвшигчийг сонгохдоо энэ хуулийн 8.2.1, 8.2.2, 8.3-т заасныг баримталж, тухайн албан тушаалыг хаших ёс зүйн болон хууль тогтоомж, холбогдох журмаар тогтоосон бусад шаардлагад үндэслэнэ.

19.6. Энэ хуулийн 19.4, 19.5-д заасан журмыг намын төлөөллийн төв байгууллага батална.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 5  
Татгалзсан: 5  
Бүгд: 10  
50.0 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн С.Амарсайханы “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дээрх санал хураалтыг хүчингүй болгож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

**Н.Энхболд:** Улсын Их Хурлын гишүүн С.Амарсайханы гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 5  
Татгалзсан: 5  
Бүгд: 10  
50.0 хувийн саналаар горимын санал дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн Ж.Сүхбаатарын “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дээрх санал хураалтыг хүчингүй болгож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

**Н.Энхболд:** Улсын Их Хурлын гишүүн Ж.Сүхбаатарын гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 6  
Татгалзсан: 4  
Бүгд: 10  
60.0 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

**Н.Энхболд:** Горимын санал дэмжигдсэн тул дээрх дэмжье гэсэн санал хураалтыг дахин явуулъя.

Зөвшөөрсөн: 6  
Татгалзсан: 4  
Бүгд: 10  
60.0 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Төслийн 34 дүгээр зүйлийн 34.3 дахь хэсгийн “тухайн улирлын хамаарах хагас жилийн төрийн санхүүжилтийг” гэснийг “сонгуулийн төв байгууллага тухайн намд энэ хуулийн 27.5-д заасан төрийн санхүүжилтийн /С1 х Т1/ хэсгийг дараагийн жилд” гэж, 34.5.3 дахь заалтын “өгсөн бол хандивыг хүлээн авснаас хойш ажлын таван өдрийн” гэснийг “хүлээн авснаа мэдсэнээс хойш ажлын арван өдрийн” гэж, 34.6.5 дахь заалтын “төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн, бусад удирдах албан тушаалтан” гэснийг “төлөөлөн удирдах

2023 ОНЫ 07 ДУГААР САРЫН 03-НЫ ӨДӨР, ДАВАА ГАРАГ

зөвлөлийн дарга” гэж тус тус өөрчилж, 34.6.8 дахь заалтын “нь илэрхий” гэснийг болон 34.5.4 дэх заалтыг хасаж, доор дурдсан агуулгатай 34.5.5, 34.12, 34.13 дахь хэсэг нэмэх:

“34.5.5.мөнгөн бус хандив авч байгаа тохиолдолд хандивлагчтай хандивын гэрээг бичгээр байгуулж гэрээнд заасан зориулалтын дагуу зарцуулах;

34.12.Хуулийн этгээд намд хандив өгсөн бол хандивын хэмжээ, зориулалтыг нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайландаа тусгана.

34.13.Намын санхүүгийн тайланд аудит хийхээр гэрээ байгуулсан аудитын хуулийн этгээд хандивын талаарх баримт, мэдээллийг хандивлагчаас гаргуулан авна.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 7  
Татгалзсан: 3  
Бүгд: 10  
70.0 хувийн саналаар дэмжигдлээ.

3.Төслийн 42 дугаар зүйлийн гарчгийн “, эсхүл ил болгоогүй” гэснийг болон 42.4 дэх хэсгийг хасаж, 42.1 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“42.1.Нам энэ хуулийн 34.5.3-т заасны дагуу хандивыг шилжүүлээгүй бол тухайн нам хууль бусаар авсан хандивыг хоёр дахин өсгөсөн дүнгээр сонгуулийн төв байгууллагад төлнө. Ийнхүү төлөх шийдвэрийг сонгуулийн төв байгууллага гаргана.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 7  
Татгалзсан: 3  
Бүгд: 10  
70.0 хувийн саналаар дэмжигдлээ.

**Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн  
42 дугаар зүйлийн 42.2.3 дахь заалтын дагуу хураалгах санал:**

Байнгын хорооны дарга Н.Энхболд дараах саналыг гуравны хоёроор хэлэлцэж дэмжих горимын санал гаргав.

**Н.Энхболд:** Горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 7  
Татгалзсан: 3  
Бүгд: 10  
70.0 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

**Н.Энхболд:** 1.Төслийн 21 дүгээр зүйлийн 21.2 дахь хэсгийн “төрийн санхүүжилтийг зогсоох бөгөөд” гэсний дараа “зөрчлийг арилгах хүртэл” гэж, 21.4 дэх хэсгийн “сонгуулийн төв байгууллага” гэсний дараа “хүлээн авснаас хойш ажлын таван өдрийн дотор Улсын дээд шүүхэд хүргүүлэх бөгөөд Улсын дээд шүүх” гэж, 21.5 дахь хэсгийн “дуусах хүртэл намыг” гэсний дараа “идэвхтэй, эсхүл” гэж тус тус нэмж, 21.5 дахь хэсгийн “сонгуулийн төв байгууллага” гэснийг “Улсын дээд шүүх” гэж өөрчилж, 21.6 дахь хэсгийг хасаж, 21.1, 21.3 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

2023 ОНЫ 07 ДУГААР САРЫН 03-НЫ ӨДӨР, ДАВАА ГАРАГ

“21.1.Улсын дээд шүүх сонгуулийн төв байгууллагаас ирүүлсэн мэдээлэлд үндэслэн дараах тохиолдолд намыг идэвхгүйд тооцох тухай шийдвэрийг гаргана.

21.3.Энэ хуулийн 21.1.1-д заасан зөрчил гаргасан намын эрх бүхий байгууллага сонгуульд оролцох шийдвэр гаргаж, сонгуулийн төв байгууллагад бүртгүүлсэн, эсхүл энэ хуулийн 21.1.2, 21.1.3-т заасан зөрчлөө арилгасан талаар холбогдох нотлох баримтыг сонгуулийн төв байгууллагад албан ёсоор хүргүүлнэ.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 6  
Татгалзсан: 4  
Бүгд: 10  
60.0 хувийн саналаар дэмжигдлээ.

Байнгын хорооны дарга Н.Энхболд дараах саналыг гуравны хоёроор хэлэлцэж дэмжих горимын санал гаргав.

**Н.Энхболд:** Горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 7  
Татгалзсан: 3  
Бүгд: 10  
70.0 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

**Н.Энхболд:** 2.Төслийн 31 дүгээр зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

**“31 дүгээр зүйл.Төрөөс үзүүлэх санхүүгийн дэмжлэгт тавих хяналт**

31.1.Сонгуулийн төв байгууллага төрөөс үзүүлэх санхүүгийн дэмжлэг, түүний зарцуулалтын тайланг хянаж, хүлээн авч нэгтгэн тайлагнана.

31.2.Сонгуулийн төв байгууллага энэ хуулийн 38 дугаар зүйлд заасны дагуу намын санхүүгийн тайланд аудитын хуулийн этгээдээр хараат бусаар дүгнэлт гаргуулах ажлыг зохион байгуулж, хяналт тавина.

31.3.Төрийн аудитын байгууллага нь сонгуулийн төв байгууллагын төсвийн багцад туссан намд олгох төрийн санхүүжилт, түүний зарцуулалт, тайлагналд Төсвийн тухай хуульд заасан цаглаврын дагуу аудит хийж, дүгнэлт гаргана.

31.4.Намд төрийн санхүүжилт олгох, төрөөс үзүүлэх шууд бус дэмжлэгийг шийдвэрлэх, намын санхүүгийн тайлан болон үйл ажиллагааны товч тайланг хянах, дүгнэлт гаргах, тайлагнах, нийтэд мэдээлэх, намын баримт бичиг, мэдээллийг цахим хуудаст байршуулах, шинэчлэх, хариуцлага тооцохтой холбоотой журмыг энэ хуульд нийцүүлэн төрийн аудитын байгууллагын саналыг харгалзан сонгуулийн төв байгууллага батална.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 7  
Татгалзсан: 3  
Бүгд: 10  
70.0 хувийн саналаар дэмжигдлээ.

2023 ОНЫ 07 ДУГААР САРЫН 03-НЫ ӨДӨР, ДАВАА ГАРАГ

Байнгын хорооны дарга Н.Энхболд дараах саналыг гуравны хоёроор хэлэлцэж дэмжих горимын санал гаргав.

**Н.Энхболд:** Горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 7  
Татгалзсан: 3  
Бүгд: 10  
70.0 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

**Н.Энхболд:** 3.Төслийн 43 дугаар зүйлийн 43.1, 43.2 дэх хэсгийн “4 дүгээр сард” гэснийг “05 дугаар сард” гэж, “зохих тоогоор” гэснийг “тухай бүр эмхэтгэж” гэж, 43.8 дахь хэсгийн “иргэний, овог, нэр, оршин суугаа” гэснийг “иргэний овог, нэр, эсхүл хуулийн этгээдийн нэр, оршин байгаа” тус тус өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 7  
Татгалзсан: 3  
Бүгд: 10  
70.0 хувийн саналаар дэмжигдлээ.

*Улс төрийн намын тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн талаар ажлын хэсгээс гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулав.*

1.Улс төрийн намын тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн төслийн талаар:

**Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.2.1 дэх заалтын дагуу хураалгах санал:**

**Н.Энхболд:** Төслийн 3 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

**3 дугаар зүйл.** Намд төрөөс үзүүлэх санхүүгийн дэмжлэг, намын санхүүгийн тайлан гаргах, тайланг нийтэд мэдээлэх, намыг идэвхгүйд тооцохтой холбоотой зохицуулалтыг Монгол Улсын Их Хурлын 2024 оны ээлжит сонгуулийн дүнгээр байгуулагдах Улсын Их Хурлын бүрэн эрх хэрэгжиж эхэлсэн өдрөөс дагаж мөрдөнө гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 7  
Татгалзсан: 3  
Бүгд: 10  
70.0 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Зөрчлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн талаар:

**Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.2.1 дэх заалтын дагуу хураалгах санал:**

**Н.Энхболд:** Төслийн 1 дүгээр зүйлийн 1 дэх заалтын 17.2 дугаар зүйлийн 1 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

2023 ОНЫ 07 ДУГААР САРЫН 03-НЫ ӨДӨР, ДАВАА ГАРАГ

“1.Нам нь Улс төрийн намын тухай хуулийн 10.1.6-д заасан хориглолтыг зөрчиж мөнгөн хөрөнгө авсан бол тухайн мөнгөн дүнг хоёр дахин үржүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

2.Нам нь Улс төрийн намын тухай хуулийн 10.1.6-д заасан хориглолтыг зөрчиж мөнгөн бус хөрөнгө, үйлчилгээ авсан бол хууль бусаар авсан хөрөнгө, орлогыг хурааж хорин мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 7  
Татгалзсан: 3  
Бүгд: 10  
70.0 хувийн саналаар дэмжигдлээ.

3.Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар:

**Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.2.1 дэх заалтын дагуу хураалгах санал:**

**Н.Энхболд:** Төсөлд доор дурдсан агуулгатай 1 дүгээр зүйл нэмэх:

“1 дүгээр зүйл.Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуулийн 3 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 3.2 дахь хэсэг нэмсүгэй:

“3.2.Улс төрийн намыг шинээр үүсгэн байгуулах, өөрчлөн байгуулах, татан буулгах, түүний мэдээлэлд оруулсан өөрчлөлтийг намын бүртгэлд бүртгэх, иргэн, хуулийн этгээд, эрх бүхий байгууллага, албан тушаалтанд лавлагаа олгох, намын бүртгэл хөтлөхтэй холбогдсон харилцааг Улс төрийн намын тухай хуулиар зохицуулна.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 7  
Татгалзсан: 3  
Бүгд: 10  
70.0 хувийн саналаар дэмжигдлээ.

4.Монгол Улсын шүүхийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар:

**Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.2.1 дэх заалтын дагуу хураалгах санал:**

**Н.Энхболд:** Төсөлд доор дурдсан агуулгатай 1 дүгээр зүйл нэмэх:

“1 дүгээр зүйл.Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 85 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 85.6 дахь хэсэг нэмсүгэй:

“85.6.Улсын дээд шүүхийн Тамгын газрын бүтэц, орон тоог ажлын ачаалал, онцлогийг харгалзан тус шүүхийн шүүгчдийн зөвлөгөөн батална. Улсын дээд шүүхийн Тамгын газар нь энэ хуулийн 25.8.8-д заасан бүрэн эрхийг хэрэгжүүлэхэд туслах чиг үүрэг бүхий нэгжтэй байна.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.



2023 ОНЫ 07 ДУГААР САРЫН 03-НЫ ӨДӨР, ДАВАА ГАРАГ

Зөвшөөрсөн: 6  
Татгалзсан: 4  
Бүгд: 10  
60.0 хувийн саналаар дэмжигдлээ.

*Зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулж дуусав.*

Улсын Их Хурлын гишүүн Д.Тогтохсүрэн “Хууль баталсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөлд “авах, төсвийг шийдвэрлэх” гэсэн үгийг нэмэх гэсэн горимын санал гаргав.

*“Хууль баталсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн талаар ажлын хэсгээс гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулав.*

**Н.Энхболд:** Улс төрийн намын тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийг баталсантай холбогдуулан уг хууль хүчин төгөлдөр мөрдөгдөж эхэлсэн өдрөөс хойш энэ хуулийг хэрэгжүүлэхэд шаардлагатай арга хэмжээ авах, төсвийг шийдвэрлэх, холбогдох журмыг батлахыг Монгол Улсын Засгийн газар /Л.Оюун-Эрдэнэ/, Монгол Улсын Сонгуулийн ерөнхий хороо /П.Дэлгэрнаран/-нд тус тус даалгасугай гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 6  
Татгалзсан: 4  
Бүгд: 10  
60.0 хувийн саналаар дэмжигдлээ.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Д.Тогтохсүрэн Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

*Уг асуудлыг 11 цаг 00 минутад хэлэлцэж дуусав.*

***Хоёр.Жендерийн эрх тэгш байдлыг хангах тухай хуульд өөрчлөлт оруулах тухай болон Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Улс төрийн намын тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/***

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Монгол Улсын Ерөнхийлөгчийн Хууль зүйн бодлогын зөвлөх А.Бямбажаргал, Үндэсний аудитын газрын Хөгжлийн бодлого төлөвлөлтийн газрын захирал, тэргүүлэх аудитор Б.Бундхорол, Сонгуулийн ерөнхий хорооны Ажлын албаны дарга Д.Баяндүүрэн, мөн хорооны Хууль, эрх зүйн хэлтсийн дарга Д.Бат-Эрдэнэ, Монгол Улсын Их сургуулийн Үндсэн хуулийн эрх зүйн хүрээлэнгийн захирал, Хууль зүйн сургуулийн профессор, хууль зүйн доктор О.Мөнхсайхан, мөн сургуулийн Улс төр судлалын тэнхимийн профессор Д.Бумдарь, судлаач Э.Гэрэлт-Од, судлаач Д.Энхцэцэг нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Б.Төгсцэнгэл, Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн дарга Д.Энхбат, мөн хэлтсийн референт Б.Галсанбат, Төрийн байгуулалтын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Б.Хатантуул, референт Э.Баттогтох нар байлцав.

2023 ОНЫ 07 ДУГААР САРЫН 03-НЫ ӨДӨР, ДАВАА ГАРАГ

*Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.10-т заасны дагуу Жендерийн эрх тэгш байдлыг хангах тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэв.*

Төслийн 1, 2 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Улсын Их Хурлын гишүүн Д.Тогтохсүрэн Жендерийн эрх тэгш байдлыг хангах тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг эцэслэн батлах үе шаттай нэгтгэн явуулах горимын санал гаргав.

**Н.Энхболд:** Улсын Их Хурлын гишүүн Д.Тогтохсүрэнгийн гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 6  
Татгалзсан: 4  
Бүгд: 10  
60.0 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

*Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.10-т заасны дагуу Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэв.*

Төслийн 1, 2, 3 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Улсын Их Хурлын гишүүн Д.Тогтохсүрэн Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг эцэслэн батлах үе шаттай нэгтгэн явуулах горимын санал гаргав.

**Н.Энхболд:** Улсын Их Хурлын гишүүн Д.Тогтохсүрэнгийн гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 6  
Татгалзсан: 4  
Бүгд: 10  
60.0 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн М.Оюунчимэг Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

*Уг асуудлыг 11 цаг 06 минутад хэлэлцэж дуусав.*

**Гурав.Хуулийн давхардал, хийдэл, зөрчлийг арилгах зорилгоор боловсруулсан Үндэсний их баяр наадмын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай болон Хөдөлмөрийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүд /Засгийн газар 2023.06.23-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/**

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга П.Сайнзориг, мөн яамны Хууль зүй бодлогын газрын Хувийн эрх зүйн хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Н.Жамъянхүү, Монголын

2023 ОНЫ 07 ДУГААР САРЫН 03-НЫ ӨДӨР, ДАВАА ГАРАГ

үндэсний бөхийн холбооны тэргүүн Ц.Магалжав, Монголын допингийн эсрэг байгууллагын гүйцэтгэх захирал Д.Мөнхболд нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Ч.Батбямба, Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Төрийн байгуулалтын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Б.Хатантуул, референт Э.Баттогтох нар байлцав.

*Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.10-т заасны дагуу Хуулийн давхардал, хийдэл, зөрчлийг арилгах зорилгоор боловсруулсан Үндэсний их баяр наадмын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай болон Хөдөлмөрийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийг зүйл бүрээр хэлэлцэв.*

*Хуулийн давхардал, хийдэл, зөрчлийг арилгах зорилгоор боловсруулсан Үндэсний их баяр наадмын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай төслийн талаар Улсын Их Хурлын гишүүнээс гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулав.*

Төслийн 2, 4, 5 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Улсын Их Хурлын гишүүн Ж.Сүхбаатар төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан үг хэлэв.

**Н.Энхболд:** Улсын Их Хурлын гишүүн Ж.Сүхбаатарын гаргасан, 1.Төслийн 1 дүгээр зүйлийн “даян аварга,” гэсний дараа “даян аварга цолтой бөх ес даван түрүүлбэл дархан аварга,” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 6  
Татгалзсан: 4  
Бүгд: 10  
60.0 хувийн саналаар дэмжигдлээ.

Улсын Их Хурлын гишүүн Ж.Сүхбаатар төслийн 3 дугаар зүйлтэй холбогдуулан үг хэлэв.

**Н.Энхболд:** Улсын Их Хурлын гишүүн Ж.Сүхбаатарын гаргасан, 2.Төслийн 3 дугаар зүйлийн “Улсын баяр наадамд түрүүлж, үзүүрлэж, шөвгөрсөн бөхийн” гэснийг “Бөхийн цолны” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 5  
Татгалзсан: 5  
Бүгд: 10  
50.0 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн А.Адьяасүрэнгийн “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дээрх санал хураалтыг хүчингүй болгож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

2023 ОНЫ 07 ДУГААР САРЫН 03-НЫ ӨДӨР, ДАВАА ГАРАГ

**Н.Энхболд:** Улсын Их Хурлын гишүүн А.Адьяасүрэнгийн гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 6  
Татгалзсан: 4  
Бүгд: 10  
60.0 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

**Н.Энхболд:** Горимын санал дэмжигдсэн тул дээрх дэмжье гэсэн санал хураалтыг дахин явуулъя.

Зөвшөөрсөн: 6  
Татгалзсан: 4  
Бүгд: 10  
60.0 хувийн саналаар дэмжигдлээ.

*Үндэсний их баяр наадмын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуультай хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслийн талаар Улсын Их Хурлын гишүүнээс гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулав.*

1.Хөдөлмөрийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар:

Төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Улсын Их Хурлын гишүүн Ж.Сүхбаатар төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан үг хэлэв.

**Н.Энхболд:** Улсын Их Хурлын гишүүн Ж.Сүхбаатарын гаргасан, Төслийн гарчгийн “өөрчлөлт” гэснийг “нэмэлт” гэж, төслийн 1 дүгээр зүйлийн ““11,” гэснийг “10,11,” гэж өөрчилсүгэй.” гэснийг ““11” гэсний өмнө “10,” гэж нэмсүгэй.” гэж тус тус өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 6  
Татгалзсан: 4  
Бүгд: 10  
60.0 хувийн саналаар дэмжигдлээ.

### **Найруулгын санал:**

**Н.Энхболд:** Төслийн 1 дүгээр зүйлийн “дараах” гэснийг “хэсэг” гэсний өмнө шилжүүлж, “хуульд” гэсний дараа “доор дурдсан” гэж, 2 дугаар зүйлийн “9.5, 9.9-д” гэсний өмнө “энэ хуулийн” гэж тус тус нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 6  
Татгалзсан: 4  
Бүгд: 10  
60.0 хувийн саналаар дэмжигдлээ.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн А.Адьяасүрэн Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

2023 ОНЫ 07 ДУГААР САРЫН 03-НЫ ӨДӨР, ДАВАА ГАРАГ

Байнгын хорооны хуралдаанаар 3 асуудал хэлэлцэв.

*Хуралдаан 48 минут үргэлжилж, 19 гишүүнээс 10 гишүүн хүрэлцэн ирж, 52.6 хувийн ирцтэйгээр 11 цаг 18 минутад өндөрлөв.*

**Тэмдэглэлтэй танилцсан:**

**ТӨРИЙН БАЙГУУЛАЛТЫН БАЙНГЫН  
ХОРООНЫ ДАРГА**

**Н.ЭНХБОЛД**

**Тэмдэглэл хөтөлсөн:**

**ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ ХӨТЛӨХ  
АЛБАНЫ ШИНЖЭЭЧ**

**П.ОЮУНГЭРЭЛ**

2023 ОНЫ 07 ДУГААР САРЫН 03-НЫ ӨДӨР, ДАВАА ГАРАГ

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ**

2023 оны 07 дугаар сарын 03-ны өдөр,  
Даваа гараг Төрийн ордон  
“Үндсэн хууль” танхим  
10 цаг 30 минут.

**БАЙНГЫН ХОРООНЫ  
ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ  
ТЭМДЭГЛЭЛ**

**Н.Энхболд:** Байнгын хорооны гишүүдийн олонх хүрэлцэн ирлээ. 19 гишүүнээс 10 ирлээ. Ирц бүрдсэн учраас 23 оны 07 сарын 03-ны өдрийн хуралдаан нээснийг мэдэгдье.

Хэлэлцэх асуудлаа танилцуулъя.

Өнөөдрийн хуралдаанаар Монгол Улсын Ерөнхийлөгчөөс энэ оны 04 сарын 14-ний өдөр өргөн мэдүүлсэн Улс төрийн намын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл хамт өргөн мэдүүлсэн хууль, Улсын Их Хурлын тогтоолын төслүүдийн эцсийн хэлэлцүүлгийг хийнэ.

2 дугаарт, мөн Засгийн газраас 06 сарын 23-ны өдөр өргөн мэдүүлсэн Хуулийн давхардал, хийдэл, зөрчлийг арилгах зорилгоор боловсруулсан Үндэсний их баяр наадмын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай болон үүнтэй уялдуулаад Хөдөлмөрийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг хийнэ.

Хэлэлцэх асуудалтай холбоотой саналтай гишүүн байна уу? Алга байна.

Хэлэлцэх асуудалдаа оръё.

**Улс төрийн намын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл хамт өргөн мэдүүлсэн хууль, Их Хурлын тогтоолын төслүүдийн эцсийн хэлэлцүүлгийг явуулъя.**

Эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн танилцуулга, зарчмын зөрөөтэй

саналуудыг гишүүдэд тараасан байгаа. Тогтохсүрэн дарга танилцуулгаа хийчих үү, эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн.

Тогтохсүрэн гишүүний утсыг өгье. Утсыг гэнэ, микрофоныг өгье.

**Д.Тогтохсүрэн:** Байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ, Монгол Улсын Ерөнхийлөгчөөс 2023 оны 04 сарын 14-ний өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Улс төрийн намын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл хамт өргөн мэдүүлсэн хууль, Улсын Их Хурлын тогтоолын төслүүдийн хэлэлцэх эсэх асуудлыг Улсын Их Хурал 2023 оны 04 сарын 20-ны өдрийн нэгдсэн чуулганаараа, анхны хэлэлцүүлгийг Улсын Их Хурал 23 оны 06 сарын 29-ний чуулганы нэгдсэн хуралдаанаараа явуулж, эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төрийн байгуулалтын байнгын хороонд шилжүүлсэн.

2023 оны 06 сарын 29-ний өдрийн Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанаар хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгүүдийг явуулах үед хуралдаан даргалагчаас өгсөн чиглэлийн дагуу Улс төрийн намын хуулийн шинэчилсэн найруулгын төслийн талаар 3 санал, хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд дээр 4, Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн 3-ны 2-оос доошгүй саналаар дахин санал хураалгах шаардлагатай 3 санал, нийт 10 зарчмын зөрөөтэй саналын томъёоллыг бэлтгэлээ.

Түүнчлэн хууль хоорондын нийцлийг хангах зорилгоор Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Жендерийн эрх тэгш байдлыг хангах тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд заасны дагуу эцсийн хэлэлцүүлгийн шатанд шинээр боловсрууллаа.

Байнгын хорооны эрхэм гишүүд ээ, Улс төрийн намын тухай хуулийн

2023 ОНЫ 07 ДУГААР САРЫН 03-НЫ ӨДӨР, ДАВАА ГАРАГ

шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн Улсын Их Хурлын хууль, Улсын Их Хурлын тогтоолын төслүүдийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх ажлын хэсгийн танилцуулга, зарчмын зөрөөтэй саналын томъёоллыг хэлэлцэж шийдвэрлэж өгөхийг хүсье. Баярлалаа.

**Н.Энхболд:** Тогтохсүрэн даргад баярлалаа. Ажлын хэсгийн гишүүдийг танилцуулъя.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн Хууль зүйн бодлогын зөвлөх Бямбажаргал, Ерөнхийлөгчийн Тамгын газрын Хуулийн бодлогын газрын дарга Машибат, ирсэн үү? Бямбажаргал зөвлөх байгаа юм байна. Бундхорол Үндэсний аудитын газрын Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн газрын захирал, тэргүүлэх аудитор, Баяндүүрэн Сонгуулийн ерөнхий хорооны ажлын албаны дарга, Бат-Эрдэнэ Сонгуулийн ерөнхий хорооны Хууль, эрх зүйн хэлтсийн дарга, Мөнхсайхан Их сургуулийн Үндсэн хуулийн эрх зүйн хүрээлэнгийн захирал, Хууль зүйн сургуулийн профессор, доктор, Мөнхсайхан ирсэн байна. Бумдарь МУИС-ийн Улс төр судлалын тэнхимийн профессор, Гэрэлт-Од судлаач доктор, Энхцэцэг судлаач ийм бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг ирсэн байна.

Одоо санал хураалт явуулна.

Санал хураалтыг Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42.2.1, 42.2.2, 42.2.3-д заасан зарчмуудын дагуу явуулна.

Санал хураалтаа эхэлье.

Улс төрийн намын тухай шинэчилсэн найруулгын төслийн талаарх зарчмын зөрөөтэй саналууд эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэж ажлын хэсгээс ирүүлсэн. Дэгийн тухай хуулийн 42.2.1 дэх заалтын дагуу хураалгах саналууд байгаа. Гүйцээн боловсруулах чиглэл чуулганы хуралдаанаас өгсөн.

Санал 1. Төслийн 19 дүгээр зүйлд доор дурдсан агуулгатай 19.4, 19.5, 19.6 дахь хэсэг нэмэх:

“19.4.Нам Улсын Их Хурлын сонгуульд намаас нэр дэвшигчийг сонгох ажлыг зохион байгуулах хороотой байж болно. Хорооны бүрэлдэхүүнд тавигдах шаардлага, түүнийг байгуулах, ашиг сонирхлын зөрчлийг зохицуулах болон үйл ажиллагааны журмыг энэ хуулийн 8 дугаар зүйл, намын дүрэмд нийцүүлнэ.

19.5.Улсын Их Хурлын сонгуульд намаас нэр дэвшигчийг сонгохдоо энэ хуулийн 8.2.1, 8.2.2, 8.3-т заасныг баримталж, тухайн албан тушаалыг хаших ёс зүйн болон хууль тогтоомж, холбогдох журмаар тогтоосон бусад шаардлагад үндэслэнэ.

19.6.Энэ хуулийн 19.4, 19.5-д заасан журмыг намын төлөөллийн төв байгууллага батална.” Ажлын хэсгийн гаргасан санал. Санал хураалт явуулъя. Дэмжих томъёоллоор санал хураалт явуулъя.

Хөөе, хэнийх үлдчихэв. Амарсайхан та саналаа хэл ээ, горимын санал.

**С.Амарсайхан:** Дэмжиж өгсөн санал эсрэг гарсан байгаа учраас горимын санал гаргаж, энэ саналыг хүчингүй болгож дахин санал хураалт хийхийг хүсье.

**Н.Энхболд:** Амарсайхан гишүүний гаргасан санал түрүүчийн санал хураалтыг хүчингүй болгох тухай горимын саналыг дэмжье гэсэн саналаар санал хураалт явуулъя. Санал хураалт. Гишүүд анхааралтай байгаарай.

Энэ яагаад дахин дахин аваад байна. Сүхбаатар гишүүнийх гарсангүй, таных гарсангүй, дахиад санал гаргачих.

**Ж.Сүхбаатар:** Би сая дэмжиж санал өгсөн, тэгээд эсрэг гарчихлаа, тийм. Дахиад санал хураалгаж өгөөч.

2023 ОНЫ 07 ДУГААР САРЫН 03-НЫ ӨДӨР, ДАВАА ГАРАГ

**Н.Энхболд:** Саяын санал хураалтыг хүчингүй болгоод дахин түрүүчийн санал хураалтыг хүчингүй болгох тухай санал хураалт явуулъя. Энэ аппаратад байна уу, юу байна. Гишүүд анхааралтай хандаарай. Санал хураалт.

60 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Санал хүчингүй болсон. Түрүүчийн уншсан томъёоллоор саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя. Санал хураалт. Дахиад гишүүд ээ, санал хураалт.

1 дүгээр санал 60 хувиар дэмжигдэж байна.

2.Төслийн 34 дүгээр зүйлийн 34.3 дахь хэсгийн “тухайн улирлын хамаарах хагас жилийн төрийн санхүүжилтийг” гэснийг “сонгуулийн төв байгууллага тухайн намд энэ хуулийн 27.5-д заасан төрийн санхүүжилтийн /C1 х T1/ хэсгийг дараагийн жилд” гэж, 34.5.3 дахь заалтын “өгсөн бол хандивыг хүлээн авснаас хойш ажлын таван өдрийн” гэснийг “хүлээн авснаа мэдсэнээс хойш ажлын арван өдрийн” гэж, 34.6.5 дахь заалтын “төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн, бусад удирдах албан тушаалтан” гэснийг “төлөөлөн удирдах зөвлөлийн дарга” гэж тус тус өөрчилж, 34.6.8 дахь заалтын “нь илэрхий” гэснийг болон 34.5.4 дэх заалтыг хасаж, доор дурдсан агуулгатай 34.5.5, 34.12, 34.13 дахь хэсэг нэмэх:

“34.5.5.мөнгөн бус хандив авч байгаа тохиолдолд хандивлагчтай хандивын гэрээг бичгээр байгуулж гэрээнд заасан зориулалтын дагуу зарцуулах;

34.12.Хуулийн этгээд намд хандив өгсөн бол хандивын хэмжээ, зориулалтыг нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайландаа тусгана.

34.13.Намын санхүүгийн тайланд аудит хийхээр гэрээ байгуулсан аудитын хуулийн этгээд хандивын талаарх баримт, мэдээллийг хандивлагчаас гаргуулан авна.” Ажлын хэсгийн санал дэмжье санал хураалт.

Гишүүдийн 70 хувиар санал дэмжигдлээ.

3.Төслийн 42 дугаар зүйлийн гарчгийн “, эсхүл ил болгоогүй” гэснийг болон 42.4 дэх хэсгийг хасаж, 42.1 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“42.1.Нам энэ хуулийн 34.5.3-т заасны дагуу хандивыг шилжүүлээгүй бол тухайн нам хууль бусаар авсан хандивыг хоёр дахин өсгөсөн дүнгээр сонгуулийн төв байгууллагад төлнө. Ийнхүү төлөх шийдвэрийг сонгуулийн төв байгууллага гаргана.” Ажлын хэсгийн санал дэмжье. Санал хураалт.

70 хувийн саналаар дэмжигдэж байна.

2 дахь бүлэг саналууд байгаа. Энэ нь чуулганы дэгийн тухай хуулийн 42.2.3 дахь заалтын дагуу 3-ны 2-оороо шийдэж явах ийм заалт байгаа. Тэгэхээр эхлээд одоо дараалж гарах 3 саналыг 3-ны 2-оор хэлэлцэж дэмжих горимын саналыг дэмжье гэсэн саналаар санал хураалт явуулъя. Санал хураалт.

Горимын санал 70 хувиар дэмжигдлээ.

Одоо саналаа танилцуулъя.

Төслийн 21 дүгээр зүйлийн 21.2 дахь хэсгийн “төрийн санхүүжилтийг зогсоох бөгөөд” гэсний дараа “зөрчлийг арилгах хүртэл” гэж, 21.4 дэх хэсгийн “сонгуулийн төв байгууллага” гэсний дараа “хүлээн авснаас хойш ажлын таван өдрийн дотор.



2023 ОНЫ 07 ДУГААР САРЫН 03-НЫ ӨДӨР, ДАВАА ГАРАГ

Энэ орж байгаа гол өөрчлөлт энэ байгаа.

Улсын дээд шүүхэд хүргүүлэх бөгөөд Улсын дээд шүүх” гэж, 21.5 дахь хэсгийн “дуусах хүртэл намыг” гэсний дараа “идэвхтэй, эсхүл” гэж тус тус нэмж, 21.5 дахь хэсгийн “сонгуулийн төв байгууллага” гэснийг “Улсын дээд шүүх” гэж өөрчилж, 21.6 дахь хэсгийг хасаж, 21.1, 21.3 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“21.1.Улсын дээд шүүх сонгуулийн төв байгууллагаас ирүүлсэн мэдээлэлд үндэслэн дараах тохиолдолд намыг идэвхгүйд тооцох тухай шийдвэрийг гаргана.

21.3.Энэ хуулийн 21.1.1-д заасан зөрчил гаргасан намын эрх бүхий байгууллага сонгуульд оролцох шийдвэр гаргаж, сонгуулийн төв байгууллагад бүртгүүлсэн, эсхүл энэ хуулийн 21.1.2, 21.1.3-т заасан зөрчлөө арилгасан талаар холбогдох нотлох баримтыг сонгуулийн төв байгууллагад албан ёсоор хүргүүлнэ.” Ажлын хэсгийн санал. Санал хураалтыг дэмжье. 3-ны 2-оор дэмжигдэх ёстой. Санал шүү, гишүүд ээ.

60 хувиар дэмжигдлээ. Горимоо 3-ны 2-оор. Нөгөөдөх нь ингэе.

Дараагийн санал энэ дээр мөн горимоор санал хураана. 3-ны 2-оор энэ асуудлыг дэмжье гэдгээр санал хураалт.

70 хувиар горимын санал дэмжигдлээ. Одоо саналаа хураая.

### **“31 дүгээр зүйл.Төрөөс үзүүлэх санхүүгийн дэмжлэгт тавих хяналт**

31.1.Сонгуулийн төв байгууллага төрөөс үзүүлэх санхүүгийн дэмжлэг, түүний зарцуулалтын тайланг хянаж, хүлээн авч нэгтгэн тайлагнана.

31.2.Сонгуулийн төв байгууллага энэ хуулийн 38 дугаар зүйлд заасны дагуу

намын санхүүгийн тайланд аудитын хуулийн этгээдээр хараат бусаар дүгнэлт гаргуулах ажлыг зохион байгуулж, хяналт тавина.

31.3.Төрийн аудитын байгууллага нь сонгуулийн төв байгууллагын төсвийн багцад туссан намд олгох төрийн санхүүжилт, түүний зарцуулалт, тайлагналд Төсвийн тухай хуульд заасан цаглаврын дагуу аудит хийж, дүгнэлт гаргана.

31.4.Намд төрийн санхүүжилт олгох, төрөөс үзүүлэх шууд бус дэмжлэгийг шийдвэрлэх, намын санхүүгийн тайлан болон үйл ажиллагааны товч тайланг хянах, дүгнэлт гаргах, тайлагнах, нийтэд мэдээлэх, намын баримт бичиг, мэдээллийг цахим хуудаст байрцуулах, шинэчлэх, хариуцлага тооцохтой холбоотой журмыг энэ хуульд нийцүүлэн төрийн аудитын байгууллагын саналыг харгалзан сонгуулийн төв байгууллага батална.” Ажлын хэсгийн санал, санал хураалт.

70 хувиар энэ санал дэмжигдлээ.

3 дугаар санал дахиад горимоор санал хураана. Асуудлыг хэлэлцэж батлахдаа 3-ны 2-оор байна гэсэн горимын саналаар санал хураалт явуулъя.

70 хувиар дэмжигдлээ.

Одоо үндсэн саналаараа санал хураана.

Ажлын хэсгээс гаргасан Төслийн 43 дугаар зүйлийн 43.1, 43.2 дэх хэсгийн “4 дүгээр сард” гэснийг “05 дугаар сард” гэж, “зохих тоогоор” гэснийг “тухай бүр эмхэтгэж” гэж, 43.8 дахь хэсгийн “иргэний, овог, нэр, оршин суугаа” гэснийг “иргэний овог, нэр, эсхүл хуулийн этгээдийн нэр, оршин байгаа” тус тус өөрчлөх. Саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулна.

2023 ОНЫ 07 ДУГААР САРЫН 03-НЫ ӨДӨР, ДАВАА ГАРАГ

Энэ нөгөө хандив өгсөн субъектууд дээр хуулийн этгээдийн нэр, хаягийг нэмж байгаа ийм заалт байгаа.

70 хувиар дэмжигдлээ.

Дараагийн санал.

Улс төрийн намын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн талаарх зарчмын зөрөөтэй санал.

Улс төрийн намын тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн төслийн талаарх зарчмын зөрөөтэй саналын томъёолол.

1. Үүнийг 42.2.1-ээр хураана. Ердийн дэгээр гэсэн үг. Санал.

Төслийн 3 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

**3 дугаар зүйл.** Намд төрөөс үзүүлэх санхүүгийн дэмжлэг, намын санхүүгийн тайлан гаргах, тайланг нийтэд мэдээлэх, намыг идэвхгүйд тооцохтой холбоотой зохицуулалтыг Монгол Улсын Их Хурлын 2024 оны ээлжит сонгуулийн дүнгээр байгуулагдах Улсын Их Хурлын бүрэн эрх хэрэгжиж эхэлсэн өдрөөс дагаж мөрдөнө. Санал гаргасан ажлын хэсэг, санал хураалт.

Тухайн санал 70 хувиар дэмжигдлээ.

2. Зөрчлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн талаарх зарчмын зөрөөтэй саналын томъёолол.

Үүнийг мөн дэгийн тухай хуулийн 42.2.1 дэх заалтын дагуу хураана.

1. Төслийн 1 дүгээр зүйлийн 1 дэх заалтын 17.2 дугаар зүйлийн 1 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“1. Нам нь Улс төрийн намын тухай хуулийн 10.1.6-д заасан

хориглолтыг зөрчиж мөнгөн хөрөнгө авсан бол тухайн мөнгөн дүнг хоёр дахин үржүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

2. Нам нь Улс төрийн намын тухай хуулийн 10.1.6-д заасан хориглолтыг зөрчиж мөнгөн бус хөрөнгө, үйлчилгээ авсан бол хууль бусаар авсан хөрөнгө, орлогыг хурааж хорин мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.” Ажлын хэсгийн гаргасан санал, дэмжье. Санал хураалт.

Энэ санал гишүүдийн 70 хувийн саналаар дэмжигдэж байна.

Санал байвал микрофонд хэлж болно, дарга.

Дараагийн санал. Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуульд өөрчлөлт ор оруулах тухай хуулийн төслийн талаарх зарчмын зөрөөтэй саналын томъёолол.

Үүнийг мөн дэгийн хуулийн 42.2.1 дэх заалтын дагуу хураана, саналыг. Санал.

1. Төсөлд доор дурдсан агуулгатай 1 дүгээр зүйл нэмэх:

“1 дүгээр зүйл. Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуулийн 3 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 3.2 дахь хэсэг нэмсүгэй:

“3.2. Улс төрийн намыг шинээр үүсгэн байгуулах, өөрчлөн.

Үүнийг чинь 3-ны 2-оор юм байна шүү дээ. Үгүй юу.

“3.2. Улс төрийн намыг шинээр үүсгэн байгуулах, өөрчлөн байгуулах, татан буулгах, түүний мэдээлэлд оруулсан өөрчлөлтийг намын бүртгэлд бүртгэх, иргэн, хуулийн этгээд, эрх бүхий байгууллага, албан тушаалтанд лавлагаа олгох, намын бүртгэл хөтлөхтэй

2023 ОНЫ 07 ДУГААР САРЫН 03-НЫ ӨДӨР, ДАВАА ГАРАГ

холбогдсон харилцааг Улс төрийн намын тухай хуулиар зохицуулна.” Ажлын хэсгийн санал, санал хураалт.

Санал аа, гишүүд ээ.

70 хувиар санал дэмжигдэж байна.

Дараагийн санал.

Монгол Улсын шүүхийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаарх зарчмын зөрөөтэй саналын томъёолол.

Үүнийг мөн дэгийн тухай хуулийн 42.2.1 дэх заалтын дагуу явуулна.

Доор дурдсан агуулгатай 1 дүгээр зүйл нэмэх, төсөлд.

**“1 дүгээр зүйл.** Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 85 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 85.6 дахь хэсэг нэмсүгэй:

“85.6. Улсын дээд шүүхийн Тамгын газрын бүтэц, орон тоог ажлын ачаалал, онцлогийг харгалзан тус шүүхийн шүүгчдийн зөвлөгөөн батална. Улсын дээд шүүхийн Тамгын газар нь энэ хуулийн 25.8.8-д заасан бүрэн эрхийг хэрэгжүүлэхэд туслах чиг үүрэг бүхий нэгжтэй байна.” Ажлын хэсгийн санал, санал хураалт. Санал хураалт.

Тийм. Яг энэ намын асуудал хариуцсан намыг бүртгэхтэй холбоотой байсан.

Нийт гишүүдийн 60 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

Улс төрийн намын тухай хууль шинэчилсэн найруулгын төсөлд холбогдож гарах бусад хуулиудын талаар зарчмын зөрөөтэй саналуудаар санал хурааж дууслаа.

Тогтохсүрэн гишүүнд үг өгье.

**Д.Тогтохсүрэн:** Энд нэг зарчмын зөрөөтэй санал оруулах гээд байгаа юм. Дагаж гарах тогтоол дээр шаардлагатай арга хэмжээ авч, холбогдох журмыг батлахыг Засгийн газар Оюун-Эрдэнэ, Сонгуулийн хороо Дэлгэрнаранд даалгасугай гэгчихсэн юм. Тэгэхээр энэ тэрнийг ингэж найруулъя гээд байгаа юм, манайхан ярьж байгаад. Шаардлагатай арга хэмжээ авах таслал тавиад төсвийг шийдвэрлэх, төсвийг шийдвэрлэх гэсэн ийм зарчмын зөрөөтэй санал болж байгаа юм. Тийм учраас ийм байдлаар орно гээд зарчмын зөрөөтэй саналаар хураалгамаар байгаа юм.

Үгүй, үгүй, үгүй, үгүй. Хууль баталсантай холбогдуулан авах тогтоол дээр авах төсвийг шийдвэрлэх гэдэг 3 үгийг нэмж тусгах гээд байгаа юм. Оюун-Эрдэнэ гэдгийн өмнө. Энэ үгүй ээ, би уул нь ийм юмыг манайхан болохгүй гээд байгаа юм. Уул нь ийм үг байгаа юм. Шаардлагатай арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг гэгчихсэн байхгүй юу. Тэгсэн чинь төсөв энэ дотор орохгүй гээд байгаа юм, уул нь ормоор л юм. Яах вэ, энэ хууль баталсантай холбогдуулаад одоо 24 он дээр дээд шүүхийн зардал дээр нэмэгдэнэ, Сонгуулийн хороо зардал нэмэгдэнэ. Харин одоо би 3 үг хэлэх гээд байна. Авах, төсвийг шийдвэрлэх гэдэг 3 үгийг нэмэх гээд биччихмээр байгаа юм. Хууль баталсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай тогтоолын 1 дүгээр заалт дээр. 1 дүгээр заалт дээр авах, төсвийг шийдвэрлэх гэдэг үгийг нэммээр байгаа юм. Авах, төсвийг шийдвэрлэх гэсэн ийм 3 үг нэмчихмээр байгаа юм. Тийм. Эсвэл 1 дүгээр зүйлийг дараах хуулиар өөрчлөн найруулсугай л гэгчихье. Өөрчлөн найруулах гэж. Тийм, холбогдох журам нь Сонгуулийн хорооных. Журам батлах нь. Төсөв шийдвэрлэх нь Засгийн газрынх.

**Н.Энхболд:** Намын тухай хууль, холбогдох бусад хуулиудтай холбогдсон саналуудаар санал хурааж дууссан. Одоо энэ Улс төрийн намын тухай хууль батлагдсантай холбогдуулаад авах арга

2023 ОНЫ 07 ДУГААР САРЫН 03-НЫ ӨДӨР, ДАВАА ГАРАГ

хэмжээний тухай Их Хурлын тогтоолын төслийн асуудал байна.

Энэ дээр ажлын хэсгээс гарсан саналын дагуу Их Хурлын тогтоолын 1 дэх заалтыг Улс төрийн намын тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийг баталсантай холбогдуулан уг хууль хүчин төгөлдөр мөрдөгдөж эхэлсэн өдрөөс хойш энэ хуулийг хэрэгжүүлэхэд шаардлагатай арга хэмжээ авах, төсвийг шийдвэрлэх, холбогдох журмыг батлахыг Монгол Улсын Засгийн газар Оюун-Эрдэнэ, Монгол Улсын Сонгуулийн ерөнхий хороо Дэлгэрнаранд тус тус даалгасугай гэсэн 1 дүгээр зүйлийг өөрчлөн найруулах санал гарч байна.

Саналтай холбоотой гишүүн байна уу. Асуух санал хэлэх. Байхгүй бол саяын томъёоллоор. Тэр үгнүүдээ дахиад хараарай, авах, төсвийг шийдвэрлэх, холбогдох.

Сая дагаж гарч байгаа тогтоолын 1 дүгээр зүйлд өөрчлөлт оруулах тухай уншиж танилцуулсан, саналын томъёолол. Энэ саналыг дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя.

60 хувиар санал дэмжигдлээ.

Тогтоолын төслийг хэлэлцэж дууслаа.

Тогтохсүрэн дарга чуулганд танилцуулчхаарай. Тийм.

11.00 цаг

Дараагийн асуудалдаа оръё, гишүүд ээ.

**Жендерийн эрх тэгш байдлыг хангах тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлэг явуулна.**

Улс төрийн намын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслийн

анхны хэлэлцүүлгийг явуулах үед ажлын хэсгээс боловсруулсан зарчмын зөрөөтэй саналын томъёоллууд дэмжигдсэн.

Үүнтэй холбогдуулаад чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 40 дүгээр зүйлд заасныг баримтлаад Жендерийн эрх тэгш байдлыг хангах тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийг боловсруулж хэлэлцэх ийм шаардлага гарсан.

Ингээд төслийг Байнгын хорооноос санаачлаад хэлэлцүүлж болно, дэгээрээ. Ингээд хуулийн төслүүдээ хэлэлцэж эхэлье.

Жендерийн эрх тэгш байдлыг хангах тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн талаарх зарчмын зөрөөтэй саналуудыг гишүүдэд танилцуулсан байгаа.

Одоо хуулийг 2 зүйлтэй хууль байгаа, гишүүд ээ.

Төслөө зүйл бүрээр нь хэлэлцэнэ. Саналтай гишүүд байвал.

1 дүгээр зүйл дээр саналтай гишүүн байна уу. Яагаад байхгүй байдаг юм.

Зарчмын зөрөөтэй санал хураах байхгүй байна. 1 дүгээр зүйлийг уншаад танилцуулчихъя, би. Энэ нөгөө түрүүчийн хуулиуд батлагдсантай холбогдуулж Жендерийн эрх тэгш байдлын тухай хуульд орж байгаа өөрчлөлт.

1 дүгээр зүйл. Жендерийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.3 дахь хэсгийн 25 хувиас гэснийг 40 хувиас гэж, 8.4 дэх хэсгийн 2 жил тутам гэснийг жил тутам гэж тус тус өөрчилсүгэй. Танилцууллаа.

1 дүгээр зүйлээр санал хурааж дууслаа, хэлэлцэж дууслаа.

2023 ОНЫ 07 ДУГААР САРЫН 03-НЫ ӨДӨР, ДАВАА ГАРАГ

2 дугаар зүйл. Энэ хуулийг Улс төрийн намын тухай хууль хаалтад шинэчилсэн найруулгыг дагаж мөрдөх журмын тухай 2 дугаар зүйлд заасан өдрөөс эхлэн дагаж мөрдөнө. Асуулттай, саналтай гишүүн байна уу. Алга байна. Хуулийн 2 дугаар зүйлийг хэлэлцэж дууслаа.

Тогтохсүрэн.

**Д.Тогтохсүрэн:** Жендерийн эрх тэгш байдлыг хангах тухай хуульд оруулж байгаа өөрчлөлттэй холбогдуулан Байнгын хорооны гишүүдээс зарчмын зөрөөтэй санал гараагүй учраас анхны хэлэлцүүлгээр нь батлах горимын саналыг гаргаж байна. Дэмжиж өгөхийг хүсье.

**Н.Энхболд:** Тогтохсүрэн даргын гаргасан хуулийн төслийг анхны хэлэлцүүлгээр нь хамтруулаад эцэслэн батлах горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя. Санал хураалт.

Санал 60 хувиар дэмжигдлээ.

Ингээд Жендерийн эрх тэгш байдлыг хангах тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулж дууслаа.

Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлэг.

Хуулийн төслийг мөн зүйл бүрээр нь хэлэлцэнэ.

1 дүгээр зүйлтэй холбоотой асуулт, саналтай гишүүн байна уу.

1 дүгээр зүйлийг хэлэлцэж дууслаа.

Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 2 дугаар зүйл дээр саналтай, асуулттай гишүүн байна уу? Алга байна. 2 дугаар хэлэлцүүлэг явуулж дууслаа.

Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр нь хэлэлцэж дууслаа.

Энэ 2-ыг чинь тусад нь тусад нь танилцуулах уу. 1-ийг нь юу яачих юм уу.

3-аа хэлээгүй юм байна, уучлаарай.

Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн 3 дугаар зүйл дээр саналтай гишүүн байна уу? Асуулттай гишүүн. Алга байна. Хэлэлцэж дууслаа.

Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөх тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлэг явуулж дууслаа.

Тогтохсүрэн гишүүн санал.

**Д.Тогтохсүрэн:** Улс төрийн намын тухай хуультай нийцүүлж гаргаж байгаа Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл дээр Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх үед зарчмын зөрүүтэй санал гараагүй учраас энэ хуулийн төслийг анхны хэлэлцүүлгээр нь батлах горимын саналыг гаргаж байгаа юм. Дэмжиж өгөхийг хүсье. Баярлалаа.

**Н.Энхболд:** Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг хэлэлцэх үеэр зарчмын зөрөөтэй санал гаргаагүй учраас анхны хэлэлцүүлгийг эцэслэн батлахтай нь хамтарч явуулъя гэсэн горимын санал гаргаж байна. Дэмжье гэсэн санал хураалт явуулъя^

60 хувиар санал дэмжигдэж байна.

Оюунчимэг гишүүн танилцуулчих уу.

Дараагийн асуудалдаа орно.

2023 ОНЫ 07 ДУГААР САРЫН 03-НЫ ӨДӨР, ДАВАА ГАРАГ

Шадар сайдыг дуудах шаардлагатай байна. Ажлын хэсгийн гишүүдэд баярлалаа. Чуулганы хуралдаан өнөөдөр болно шүү дээ, үдээс хойш.

11.06 цаг

Дараагийн асуудалдаа оръё.

**Засгийн газраас Үндэсний их баяр наадмын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай болон Хөдөлмөрийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүд өргөн мэдүүлсэн Хуулийн давхардал, хийдэл, зөрчлийг арилгах зорилгоор боловсруулсан ийм хуулиуд байгаа. Энэ төслүүдийн анхны хэлэлцүүлгийг явуулна.**

Ажлын хэсгийг оруулчхаарай.

Ажлын хэсгийг танилцуулъя.

Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Сайнзориг, Хууль зүй, дотоод хэргийн яамны Хууль зүйн бодлогын газрын Хувийн эрх зүйн хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Жамъянхүү, Монголын үндэсний бөхийн холбооны тэргүүн Магалжав, Монгол допингийн эсрэг байгууллагын гүйцэтгэх захирал Мөнхболд Монгол гэдэг юм уу Монголын гэдэг юм уу. Төрийн бус байгууллага.

Хэлэлцэх асуудалдаа оръё. Хуулийн төслийг зүйл бүрээр нь хэлэлцэнэ.

Үндэсний их баяр наадмын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн хэлэлцүүлгийг явуулъя. Хуулийн төслийг зүйл бүрээр нь хэлэлцэнэ.

1 дүгээр зүйл дээр санал, асуулттай гишүүн байна уу? Сүхбаатар сайд.

**Ж.Сүхбаатар:** Амарсайхан сайд бас ажил давхцаад байгаа учраас би Засгийн газрын гишүүнийхээ өмнөөс энэ

Төслийн 1 дүгээр зүйлийн “даян аварга;” гэсний дараа “даян аварга цолтой бөх ес даван түрүүлбэл дархан аварга;” гэж нэмэх гэсэн ийм саналын томъёоллыг гаргаж байна.

**Н.Энхболд:** Баярлалаа. Энэ дээр ажлын хэсэг хэлэх юм бий юу, байхгүй юу? Үүгээрээ ингээд явах уу?

Саяын гаргасан зарчмын зөрөөтэй саналаар Төслийн 1 дүгээр зүйлийн “даян аварга;” гэсний дараа “даян аварга цолтой бөх ес даван түрүүлбэл дархан аварга;” гэж нэмэх саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Санал 60 хувиар дэмжигдлээ.

1 дүгээр зүйлээр санал хураалт явуулж дууслаа.

Төслийн 2 дугаар зүйл дээр асуулт саналтай гишүүн байна уу. Алга байна.

2 дугаар зүйлээр санал хураалт явуулж дууслаа.

Төслийн 3 дугаар зүйл дээр саналтай гишүүн байна уу? Сүхбаатар гишүүн.

**Ж.Сүхбаатар:** Төслийн 3 дугаар зүйлийн “Улсын баяр наадамд түрүүлж, үзүүрлэж, шөвгөрсөн бөхийн” гэснийг “Бөхийн цолны” гэж өөрчлөх санал. Амарсайхан сайдын өмнөөс гаргаж байна.

**Н.Энхболд:** Гишүүд, ажлын хэсгээс саналтай, асуулттай гишүүн байна уу? Алга байна.

Саяын Сүхбаатар сайдын уншсан томъёоллоор энэ саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя. Санал хураалт.

Ингэсэн юм, энэ дээрээ зөвхөн үзүүрлэсэн, түрүүлсэн, шөвгөлөсөн гээд байж байсан байхгүй юу. Тэгэхээр нөгөө бусад бөхчүүдийнхээ эрэмбийг хэн

2023 ОНЫ 07 ДУГААР САРЫН 03-НЫ ӨДӨР, ДАВАА ГАРАГ

тогтоож байх юм бэ гэдэг юм нь үлдчихээд байгаа юм. Тэгэхээр ерөөсөө л бүх л бөхчүүдийнхээ ямар цолтой байна, аймаг, сум, бүх шатны хүмүүсийг.

Хэнийх уначхав. Би ярьж байгаад, Адьяасүрэн гишүүн санал гаргаарай, та. Адьяасүрэн гишүүн.

**А.Адьяасүрэн:** Дарга, миний нөгөө төхөөрөмж ажилласангүй. Дахиад санал хураалт явуулж өгнө үү.

**Н.Энхболд:** Саяын саналыг хүчингүй болгоё гэсэн санал хураалт явуулъя. Адьяасүрэн гишүүний горимоор санал хураалт.

Санал хураалт.

60 хувиар дэмжигдлээ.

Төслийн 3 дугаар зүйлээр санал хураалт явуулж дууслаа.

Тийм, хүчингүй болгосон шүү.

Одоо дахиад түрүүн “Улсын баяр наадамд түрүүлж, үзүүрлэж, шөвгөрсөн бөхийн” гэснийг “Бөхийн цолны” гэж өөрчлөх саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

60 хувиар санал дэмжигдлээ.

3 дугаар зүйлээр санал хураалт явуулж дууслаа.

Хуулийн төслийн 4 дүгээр зүйл дээр асуулт, саналтай гишүүн байна уу. Алга байна.

5 дугаар зүйл дээр асуулт, саналтай гишүүн байна уу. Байхгүй байна.

Үндэсний их баяр наадмын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр нь хэлэлцэж дууслаа.

Хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд байгаа.

Хөдөлмөрийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай.

Хөдөлмөрийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 1 дүгээр зүйл дээр асуулт, саналтай гишүүн байна уу. 1 дүгээр зүйл. Сүхбаатар гишүүний микрофоныг өгье.

**Ж.Сүхбаатар:** Энэ Хөдөлмөрийн хуулийн найруулгын санд биш биз дээ?

**Н.Энхболд:** Биш ээ, өөрчлөлт.

**Ж.Сүхбаатар:** Төслийн гарчгийн “өөрчлөлт” гэснийг “нэмэлт” гэж, төслийн 1 дүгээр зүйлийн ““11,” гэснийг “10,11,” гэж өөрчилсүгэй.” гэснийг ““11” гэсний өмнө “10,” гэж нэмсүгэй.” гэж тус тус өөрчлөх.

**Н.Энхболд:** Энэ нөгөө 10-ны өдрийг албан ёсоор амралтын өдөр болгож байгаа тухай ийм заалт байгаа. Энэ саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Санал өгсөн гишүүдийн 60 хувиар энэ санал дэмжигдлээ.

Төслийн 1 дүгээр зүйлээр санал хураалт явуулж дууслаа.

Хөдөлмөрийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 2 дугаар зүйл дээр асуулт, саналтай гишүүн байна уу? Алга байна.

Хөдөлмөрийн тухай хуульд өөрчлөлт тухай хуулийн төслийг зүйл бүрээр нь хэлэлцэж дууслаа.

Найруулгын саналууд байгаа.

Үүнийг ээ яриад санал хураагаад дэмжчихье, тэгэх үү. Найруулгын санал байна.

2023 ОНЫ 07 ДУГААР САРЫН 03-НЫ ӨДӨР, ДАВАА ГАРАГ

*Төслийн 1 дүгээр зүйлийн “дараах” гэснийг “хэсэг” гэсний өмнө шилжүүлж, “хуульд” гэсний дараа “доор дурдсан” гэж, 2 дугаар зүйлийн “9.5, 9.9-д” гэсний өмнө “энэ хуулийн” гэж тус тус нэмэх найруулгын санал байна. Үүнийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.*

*Санал хураалт. Санал 60 хувиар дэмжигдлээ.*

*Ингээд Их баяр Үндэсний баяр наадамд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль Хөдөлмөрийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгүүдийг явуулж дууслаа.*

*Санал дүгнэлтийг Адьяа гишүүн танилцуулчих уу.*

*Төрийн байгуулалтын байнгын хороо хэлэлцэх асуудлууд дууслаа.*

*Энэ өдрийн хуралдаан өндөрлөснийг мэдэгдье.*

*Гишүүддээ баярлалаа.*

*Ажлын хэсгийнхэнд баярлалаа.*

*11.18 цаг*

*Хуралдаан хаасныг мэдэгдье.*

**ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ  
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ  
БУУЛГАЖ, ХЯНАСАН:  
ШИНЖЭЭЧ**

**П.ОЮУНГЭРЭЛ**